

## “ЦАГААН СУВАРГА” БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗРЫН

### НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.2 болон 27.4.4-т заасны дагуу сонсох ажиллагааг утсаар болон бичгээр саналыг авсан. Цагаан суваргын нөлөөллийн бүсэд байрлаж байгаа 3 жуулчны бааз, 4 гэр буудлаас санал асуулгын хуудсыг утсаар ярьж бөглөсөн. Өлзийт сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хүсэлт болон Цагаан суваргын нөлөөллийн бүсийн 3 аж ахуйн нэгж, 4 гэр буудлаас санал асуулга явуулж саналыг нэгтгэхэд 83,3% нь гадаад, дотоод ялгамжгүй 5000 төгрөгөөр төлбөр хураамж авах, 16,6% нь гадаад 10000 төгрөг болгох санал гаргасан.

Мөн <http://baigali.du.gov.mn/3313> сайтаар санал асуулгын загварыг 2023 оны 04 сарын 10 –аас 2023 оны 07 сарын 10 хүртэл 3 сарын хугацаатай байршуулж санал авсан.

Цагаан суваргыг үзсэн хөтөч, жолоочид жуулчдын төлбөр, хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай зөвлөж байсан. Өмнөговь аймгийн Баян заг орон нутгийн тусгай хамгаалалттай газарт нэвтрэхэд гадаад жуулчид 12000 төгрөг авдаг болсон. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хамгаалалтын менежментийг хэрэгжүүлдэг “Хустай байгалийн цогцолборт газар” нэвтрэхэд гадаад жуулчнаас 35000 төгрөгийн хураамж авдаг.

#### Төлбөр хураамж тогтоосон бусад үзэсгэлэнт газруудын тариф

№	Төлбөр хураамж тогтоосон байгалийн үзэсгэлэнт газар	Гадаад ₮	Дотоод ₮	Үнэ
1	“Баянзаг” байгалийн үзэсгэлэнт газар	12000	3000	
2	Хустай байгалийн цогцолборт газар	35000	5000	
3	Өгий нуур	-	-	5000
4	Бага газрын чулуу	5000		-

“Цагаан суварга” байгалийн үзэсгэлэнт газрын нэвтрэх цэгээр 2023 оны 09 сарын 01-ны байдлаар 7000 жуулчинд тасалбар борлуулж 14 сая төгрөгийн орлого олсон. Цагаан суваргын төлбөр хураамжийн цэгт 1 хүн ажиллаж байгаа бөгөөд нийт жуулчдын 70%-д тасалбар түгээсэн өөр бусад газраар төлбөргүй 30% нь үздэг гэсэн тооцоог харуул, сахиулаас авсан.

Төлбөр хураамжийн орлогыг нэмэгдүүлснээр Цагаан суваргын доогуур машинтай зорчдог явдлыг зогсоож, хамгаалалтын хаалт хийх, ариун цэврийн байгууламж, ОО хийх, мэдээллийн самбарыг шинэчлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх боломжтой юм. Төлбөр хураамжийн орлогыг сумын байгаль хамгаалах санд төвлөрүүлж, жил бүрийн төлөвлөгөөг баталж ажиллах юм.